



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Коронавирус /КОВИД-19/ халдвараас
урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд
“Нэг хаалга-Нэг шинжилгээ” ажлыг
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх заалт, 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалт, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” зохион байгуулах хуваарь, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2021 оны 02 дугаар сарын 09-ний 03/661 тоот албан бичгийн дагуу “Нэг хаалга-Нэг шинжилгээ” зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажилтнуудын нэрс, хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажилтнуудын ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Нэг хаалга-Нэг шинжилгээ” зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулахдаа халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөж, тайлан мэдээг ахлагчдаа хүргүүлж ажиллахыг нийт ажилтнуудад, нэгдсэн тайлан мэдээг дүүргийнхээ Онцгой комисст цаг тухай бүрт хүргүүлж ажиллахыг дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (Б.Тэнгэрцэцэг)-д, ажилтнуудыг удирдлага, арга зүйгээр хангаж даалгавар өгч, биелэлтийг хангуулан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулж, зааварчилгаа хүргүүлэн ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д тус тус даалгасугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 4 788 600 (дөрвөн сая долоон зуун наян найман мянга зургаан зуун) төгрөгийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу Хот төлөвлөлт, судалгааны институтийн 2021 оны үйл ажиллагааны бусад зардлаас, нийтээр амрах баярын өдөр болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтнуудад хөдөлмөрийн хуулийн дагуу цалин хөлсийг тус тус бодож олгохыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.РЭГЗМАА